

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН 2014 ОНЫ НӨХЦӨЛ, БАЙДАЛ

Энэхүү тоймоор 2014 оны үнэт цаасны зах зээлийн хөгжлийн болон дэд бүтцийн статистик үзүүлэлтүүдийн өнөөгийн байдлыг авч үзэхийг зорьсон болно.

Үнэт цаасны зах зээлийн бодит нөхцөл, байдлыг илрүүлэн шинжлэхэд зайлшгүй хөгжлийн статистик үзүүлэлтүүдэд нарийвчилсан шинжилгээг хийж, тулгамдсан асуудлуудыг илрүүлэн, уг асуудлуудыг шийдвэрлэх бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх шаардлага тулгардаг.

Үнэт цаасны зах зээлийн хөгжлийг зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадварын түвшин, зах зээлийн үнэлгээг дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан хувь, нийт арилжаа хэмжээ, индексийн үзүүлэлтүүдээр голчлон хэмждэг бөгөөд дээрх үзүүлэлтүүдийн ерөнхий төлөв, хандлагаас зах зээлийн бодит нөхцөл, байдлыг тодорхойлох боломжтой.

2007-2014 оны байдлаарх үнэт цаасны зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүдийг хүснэгтээр үзүүлбэл дараах байдалтай байна.

Хүснэгт-1

Д/Д	Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/	ЗЗҮ-ний ДНБ-д харьцуулсан хувь	Хөрвөх чадвар	Арилжааны хэмжээ /тэрбум төгрөг/	Топ-20 индекс	Бүртгэлтэй хувьцаат компанийн тоо	Мэргэжлийн оролцогчдын тоо
2007	716.3	15.6 %	0.09	10.2	10618.8	383	36
2008	515.9	8.4%	0.12	62.3	5583.2	376	46
2009	620.7	10.2%	0.04	23.2	6189.9	358	48
2010	1373.9	16.3%	0.05	92.9	14759.8	336	52
2011	2104.7	20.0%	0.05	350.2	21687.5	330	92
2012	1799.9	12.9%	0.08	145.1	17714.5	328	97
2013	1670.5	10.5%	0.06	98.6	16301.8	323	93
2014	1442.6	-	0.02	60.4	14854.2	304	75

Зах зээлийн үнэлгээ 2014 оны жилийн эцсийн байдлаар 1442.66 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байгаа нь өмнөх оны мөн үеэс 227.87 тэрбум төгрөгөөр буюу 13,6%-иар буурсан үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 15264.58 нэгж, доод үзүүлэлт 14475.2 нэгж, дундаж үзүүлэлт 14832.98 нэгж, хаалтын ханш 14854.24 нэгж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1447.57 нэгжээр буюу 8.9%-иар буурсан байна.

Зах зээлийн үнэлгээ буурахад эдийн засгийн өсөлт удааширсан, уул уурхайн салбарын компанийн хувьцааны үнэ ханш дотоодын болон олон улсын хөрөнгийн бирж дээр огцом буурсан, гадаадын хөрөнгө оруулагчдын үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулах сонирхол 2012 оноос хойш эрс буурсан, зах зээлийн дэд бүтэц сул зэрэг нь голчлон нөлөө үзүүлжээ.

Зах зээлийн үнэлгээ манай нөхцөлд эдийн засгийн өсөлтөөс шууд хамааралтай буюу мөчлөг дагасан шинжтэй, мөн цөөн тооны хувьцаат компаниудын үнэлгээнээс бүрддэг, бүтээгдэхүүний нийлүүлэлт дутмагаас шалтгаалж буурсан байна.

График-1



Зах зээлийн үнэлгээг бүрдүүлэгч 30 компаниас 20 компанийн хувьцааны үнэ ханшинд тулгуурлан ТОП-20 индексийн сагсыг тооцож байгаа өнөөгийн нөхцөлд ТОП-20 индексийн үзүүлэлтийн өсөлт, бууралт нь зах зээлийн үнэлгээнээс шууд шалтгаалж байна.

Зах зээлийн хөрвөх чадвар

Хүснэгт - 2

Огноо	Зах зээлийн үнэлгээ /тэрбум.төг/	Хувьцааны арилжааны үнийн дүн /тэрбум.төг/	Хөрвөх чадвар
2006	131,2	12,6	0,096
2007	716,3	62,1	0,087
2008	515,9	60,3	0,117
2009	620,7	23,2	0,037
2010	1373,9	62,9	0,046
2011	2104,7	109,1	0,052
2012	1 799,90	144,7	0,080
2013	1 670,53	97,6	0,058
2014	1442,66	23,1	0,016

График - 2



Тайлант хугацаанд үнэт цаасны хөрвөх чадварын түвшин 0.02 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс даруй 0.04 нэгжээр буюу 65 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Хөрвөх чадварын түвшин нь зах зээлд арилжигдаж буй үнэт цаасны эргэлтийг хэмжигч үзүүлэлт бөгөөд хөгжингүй зах зээлтэй орнуудын хувьд дээрх үзүүлэлт 0.80-0.90 хувь байдаг ба манай орны хувьд 0.02-0.12 хувийн хооронд хэлбэлзэж байгаа нь үнэт цаасны зах зээл эргэц зогсонго байгааг илтгэж байна.

Хөрвөх чадварын түвшинг бага байхад голчлон хөрөнгийн биржид бүртгэлттэй хувьцаат компаниудын хяналтын багц цөөн тооны хөрөнгө оруулагчдын гарт төвлөрсөн, нийт бүртгэлтэй компаниудын дийлэнх нь 75 хувиас дээш төвлөрөлтэй, нэмж үнэт цаас гаргах сонирхол бага, гадаад, дотоодын томоохон мэргэжлийн хөрөнгө оруулагч байхгүй, тэдгээрийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл дутмаг, хөрөнгийн бирж дээр маркет макерийн зуучлалын тогтолцоо хөгжөөгүй нь суурь нөлөөг үүсгэжээ.

Мөн мэргэжлийн зуучлагч байгууллагуудын санхүүгийн болон хүний нөөцийн чадавхи сул, маржин арилжаа буюу зээлээр үнэт цаас худалдан, худалдан авах үйлчилгээний төрөл хөгжөөгүй байгаа зэрэг нь хөрвөх чадварын түвшинг бага байхад давхар нөлөөлж байна.


2014 онд хөрөнгийн биржийн 255 удаагийн арилжаагаар 137 компанийн 51.7 сая ширхэг хувьцааг 24.2 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын бондыг 9 удаагийн арилжаагаар 375.5 мянган ширхэгийг 36.1 тэрбум төгрөгөөр тус тус арилжисан байна. Нийт гүйлгээний үнийн дүнг хувиар авч үзвэл 40.16%-ийг хувьцааны, 59.84%-ийг Засгийн газрын бондын арилжаа тус тус эзэлж байна.

Цаашид Засгийн газрын бондын анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжааг хөрөнгийн биржээр бүхэлд дамжуулан арилжих нөхцлийг бүрдүүлэх, Монголбанкиар дамжуулан арилжигдаж буй Засгийн газрын бондын арилжаанд банк зөвхөн өөрийн хөрөнгөөр оролцохоос бус зуучлалын үйл ажиллагаа явуулахгүй байх зохицуулалтыг бий болгох шаардлага Хорооны өмнө тулгарч байна.

Тайлант хугацаанд компанийн бондын анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаа явагдаагүй. Компанийн өрийн хэрэслийн зах зээлийг хөгжүүлэх талаар тэдгээрийн мэдлэг, мэдээллийг өсгөх, ач холбогдолыг нь ойлгуулах шаардлагатай байна.

Хувьцааны арилжааны үнийн дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад даруй 73.4 тэрбум төгрөгөөр буюу 75.2 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд идэвхтэй арилжигдсан 30 компанийн арилжааны дүн нь бирж дээрх нийт арилжааны 94.4 хувийг эзэлж байна.

График-3



Арилжааны хэмжээ өмнөх онуудаас эрс буурахад голчлон гадаадын иргэн, аж ахуйн нэгжүүд манай орны бүртгэлтэй хувьцаат компанийн хувьцааг худалдан авах сонирхол буурсан, дийлэнх хувьцаат компаниудын засаглал сул, төвлөрөл өндөр, тайлагналын ил тод тогтолцоо төлөвшөөгүй, зах зээлийн хөрвөх чадварын доогуур түвшин байгаа нь нөлөөлжээ.

Мөн иргэдийн үнэт цаасны зах зээлийн талаарх мэдлэг, мэдээлэл хомсоос гадна хувьцаа худалдан авахаасаа илүүтэйгээр банкны хадгаламжид хөрөнгөө байшуулах сонирхол өндөр, хувьцаат компаниудын засаглалд итгэх итгэл сул байгаа нь давхар нөлөөлж байна.

Улсын бүртгэлд бүртгэлтэй байгаа дийлэнх аж ахуйн нэгжүүдийн өмчлөл нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр байгуулагдсан, гэр бүлийн бизнесийн шинжийг агуулсан, дутагдалтай байгаа санхүүжилтээ үнэт цаас гаргах замаар олон нийтээс хөрөнгө татан, төвлөрүүлэх сонирхол бага, банкны богино хугацаат зээлийн санхүүжилтийг чухайлчлах хандлага давамгайлж байна. Энэ нь анхдагч зах зээлийн арилжаа болон компанийн бондын зах зээлийг хөгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.

Санхүүгийн суурь хэрэгслүүдийн чадавхи сул байгаа нь эргээд үүсмэл санхүүгийн хэрэгсэл бий болох боломжийг богдуулж байна.

Манай улсад анхдагч зах зээлийн арилжаа 2005 онд “Монгол шилтгээн” ХК хувьцаагаа олон нийтэд санал болгон арилжиснаар анх үүсэн бий болсон бөгөөд 2005-2014 оны байдлаар 12 хувьцаат компани анхдагч зах зээлд шинээр үнэт цаасаа гаргасан бол 9 хувьцаат компани нэмж үнэт цаасаа гаргах замаар үнэт цаасны зах зээлээс нийт 85.4 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Анхдагч зах зээлийн арилжаа эрчимтэй хөгжихгүй байгаад дараахь хүчин зүйлс нөлөөлж байна. Үүнд: Үнэт цаасны зах зээлийн багтаамж бага, иргэдийн тус зах зээлд итгэх итгэл сул, илүүдэл мөнгөн хөрөнгөө банкны хадгаламжид байршуулах сонирхол өндөр, андеррайтерийн компаниудын чадавхи сул, мэргэжлийн томоохон хөрөнгө оруулагчид байхгүйгээс шалтгаалан санхүүжүүлэхээр зорьж буй хөрөнгийг бүрэн татан төвлөрүүлэх боломж хомс байна.

2014 онд анхдагч зах зээлийн арилжаагаар “Мерекс” ХК 965.9 тэрбум төгрөгийн 9.6 сая ширхэг хувьцааг, “Би Ди Сек” ХК-ийн нэмж үнэт цаасаа гаргах замаар 520.7 мянган ширхэг хувьцааг 1.1 тэрбум төгрөгөөр тус тус арилжсан байна.

Мөн анхдагч зах зээлд гаргасан үнэт цаас нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын эрэлт, хэрэгцээнд нийцээгүй, анхдагч зах зээлийн дэд бүтэц хөгжөөгүй бүртгүүлэх үйл ажиллагаа давхар хянагдаж, хэт нүсэр, цаг хугацаа шаардагддаг давхар нөлөө үзүүлж байна.

Манай орны үнэт цаасны зах зээлийн бүс нутгийн интеграцид үзүүлэх нөлөөлөл сул, хөрөнгө оруулалтын банкны тогтолцоо сонгодог утгаараа үүсэн бий болоогүй, андеррайтерийн компани өөр дээрээ анхдагч зах зээлийн арилжааны захиалгын бүртгэлийн аргаар бүртгэх тогтолцоо үүссэн бий болоогүй байгаа нь хөрөнгийн биржийн арилжаагаар дамжин арилжигдах давхар чирэгдлийг бий болгож байна.

Дүгнэлт: 2014 оны үнэт цаасны зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүдийн өнөөгийн төлөв, байдлаас харахад, Засгийн газрын бондын арилжааны үзүүлэлтээс бусад үзүүлэлтүүд өмнө оны мөн үетэй харьцуулахад буурсан байна. Цаашид Хорооны зүгээс үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, дэд бүтцийн уялдаа холбоог сайжруулж, эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээнүүдийг авахаар өөрийн бүтэц, чиг үүрэгт өөрчлөлт оруулаад ажиллаж байна.

Зах зээлийн хөгжлийн газраас үнэт цаасны зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг бий болгох, дэд бүтцийн уялдаа холбоог хангасан хөгжлийн загварыг 2015 оны эхний улиралд багтаан боловсруулахаар ажиллаж байна.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ДЭД БҮТЦИЙН БОЛОН ЗУУЧЛАГЧ ЭТГЭЭДҮҮДИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ХАНДЛАГА:

2014 оны жилийн эцсийн байдлаар Хороонд 303 компани бүртгэлтэйгээс, төрийн өмчийн оролцоотой 11, төрийн өмчит 30, хувийн өмчит 262 компани байгаа бол “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн бүртгэлд нийт 237 хувьцаат компани үүнээс төрийн өмчит 21, төрийн өмчийн оролцоотой 15, хувийн өмчит 201 компани бүртгэлтэй байна.


Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувийн өмчит компаниудын дийлэнх нь өмч хувьчлалын арга хэрэгсэл хэлбэрээр үүсэн бий болсноос үүдэн компанийн хувьцааны

хяналтын багц цөөн тооны нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн гарт төвлөрч, зах зээлийн нийлүүлэлтийн талд шокын нөлөөлөл үүсгээд байна.

Хувьцаат компанийн хяналтын багцыг цөөн тооны хөрөнгө оруулагчдын гарт төвлөрсөн нь компанийн засаглал сул, дотоод мэдээлэл эзэмшигч этгээд үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах сонирхлыг бууруулж, зах зээлийн хөрвөх чадварыг бууруулах үндсэн шалтгаан болж байна.

2014 оны байдлаар Хороонд бүртгэлтэй 303 хувьцаат компанийн 193 нь 75 ба түүнээс дээш хувийн төвлөрөлтэй байна.

График-4



Хувьцаат компаниудын хувьцааны хяналтын багц нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн гарт төвлөрч, зах зээлд бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хямрал үүсэхэд дараах хүчин зүйлс ихээхэн нөлөө үзүүлсэн гэж үзэж байна.

- 1992-1995 онд төрийн өмчийн хувьцаат компаниудын хувьцааг хөрөнгийн биржийн анхдагч зах зээл дээр арилжаалах, иргэдэд цэнхэр, ягаан тасалбараар хувьцаа эзэмшүүлэх ажил хийгдсэнтэй холбоотойгоор иргэдийн үнэт цаасны зах зээлийн мэдлэг, мэдээлэлгүй байдлыг далимдуулан дотоод мэдээлэл эзэмшигч этгээдүүд гар дээрээс хувьцааны анхан шатны баримтуудыг дамын наймааны аргаар цуглуулах ажил идэвхжсэн.
- 1995-2006 онд үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа албан ёсоор эхэлж, зах зээлийн зуучлагч байгууллагууд болох брокерийн компаниуд хувьцаат компанийн удирдлага, дотоод мэдээлэл эзэмшигч этгээдийн захиалгаар иргэдийн эзэмшилийн хувьцааг хууль бусаар буюу тэдний зөвшөөрөлгүйгээр худалдан, бусдын дансанд шилжүүлж, арилжааны бус хэлцлээр биржийн арилжаанаас гадуур хувьцааг төвлөрүүлэх замаар багцлан худалдах ажиллагаа эрчимтэй явагдсанаар хувьцаат компанийн хувьцааны хяналтын багц нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн гарт төвлөрөх нөхцөл бүрдсэн.
- 2007-2009 онд үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагаа идэвхжиж, шинээр болон нэмж үнэт цаас гаргах компанийн тоо нэмэгдэж, тэдгээрийг иргэд худалдан авч хөрөнгө оруулах сонирхол өссөн боловч 2009 оны эдийн

засгийн хямралаас шалтгаалан шинээр хувьцаагаа гаргасан “Анод банк” ХК, “Зоос банк” ХК-иудын дампууралтай холбоотойгоор иргэдийн энэ зах зээлд итгэх итгэл алдарсан.

- 2010-2012 онд эдийн засгийн огцом өсөлтөөс хамаарч хөрөнгийн биржид бүртгэлтэй уул уурхайн хувьцаат компаниудын хувьцааны үнэ, ханш огцом өсч, төрөөс “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 1072 ширхэг хувьцааг иргэдэд үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэхтэй холбоотойгоор үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид шинээр данс нээх ажиллагаа идэвхжиж, хуучин хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хувьцаа эзэмшсэн иргэд дансны мэдээллээ шалгах явцад дансанд ХОЭБ-ээр эзэмшсэн хувьцаатайгаа мэдэж зах зээлд арилжих сэдлийг бий болгосноор хувьцаат компанийн төвлөрөл огцом нэмэгдсэн.
- 2013-2014 онд олон улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй уул уурхайн хувьцаат компанийн үнэ, ханш огцом унаж, эдийн засгийн өсөлт удааширсантай холбоотойгоор хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын хувьцааны үнэ ханшний өсөлт саарч, хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын дийлэнхэд нь 75 хувь ба түүнээс дээш хувийн төвлөрөл бий болсноор зах зээлийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн талд огцом шок үүсээд байна.

Компанийн засаглалын үзүүлэлтүүд:

Олон улсын туршлагаас үзэхэд компанийн засаглалыг хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулсан, хараат бус төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээ сонгосон болон санхүүгийн тайлангаа төрийн эрх бүхий байгууллага, олон нийтэд мэдээлсэн байдал, ногдол ашиг тараалт, нийгмийн хариуцлага гэсэн үзүүлэлтүүдээр голчлон авч үздэг.

2010 онд Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор Хорооны зүгээс компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр тодорхой зохицуулалтын эрх зүйн орчинг бүрдүүлж, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх захиргааны хариуцлага нэмэгдсэн. 2005-2014 оны байдлаар хувьцаат компанийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хүснэгтээр үзүүлбэл дараах байдалтай байна.

Компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр эрх зүйн орчинг бүрдүүлж байгаа хэдий ч хувийн өмчит хувьцаат компанийн дийлэнх хувь нь 75 буюу түүнээс дээш хувийн төвлөрөлтэй, хяналтын багц цөөн тооны нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн гарт төвлөрсөн байгаа өнөөгийн нөхцөлд хувьцаа эзэмшигчдийн хурал нэр төдий хуралдах, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг зөрчигдөх, ТУЗ-ийн хараат бус гишүүнийг нэр төдий сонгох, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийж компанийн өмч хөрөнгийг үрэгдүүлэх явдал хэвээр байна.

Цөөн тооны этгээдүүд компанийн хяналтын багцыг эзэмшиж буй өнөөгийн нөхцөлд санхүүгийн дутагдалтай эх үүсвэрээ нэмж үнэт цаас гаргах замаар шийдвэрлэхээсээ илүүтэйгээр сонирхлын зөрчилтэй хэлцлээр дамжуулан компанийн өмч хөрөнгийг банкны барьцаанд тавьж зээл авах ажиллагаа буурахгүй байна.

Төвлөрөл өндөртэй хувьцаат компаниуд нэмж үнэт цаас гаргах ажиллагаа зогсонго байгаа нь зах зээлийн нийлүүлэлтийн томоохон шокыг бий болгоод байна.


	Хувь нийлүүлэгчдийн хурлаа хийсэн компанийн тоо	Санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд ирүүлсэн компанийн тоо	Ногдол ашиг тараасан ХК-ийн тоо	Ногдол ашиг тараасан дүн /тэрбум төгрөг/	IPO, SPO хийсэн компанийн тоо
2005	139	152	18	0,83	1
2006	111	143	23	3,82	4
2007	119	138	28	7,35	5
2008	120	138	38	17,61	8
2009	114	121	26	14,3	4
2010	109	65	16	30,85	2
2011	124	59	28	74,25	2
2012	193	163	29	79,1	1
2013	158	204	30	11,4	-
2014	181	196	27	52,2	2

График - 5



2014 оны байдлаар 181 компани хувьцаа эзэмшигчдийн хурлаа зарлан хуралдуулж, 196 компани санхүүгийн тайлангаа Хороонд ирүүлж нийт 27 компани 52.2 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараахаар шийдвэрлээд байна.

График - 6



Хүснэгт – 4

№	Компанийн нэр	Компанийн код	Байршил	Нийт гаргасан хувьцааны тоо	Ногдол ашгийн хэмжээ /нэгж хувьцаанд/төг/	Ногдол ашгаа тараасан хэлбэр	Нийт хөрөнгө /мян.төг/	Тайлант үеийн татварын дараах цэвэр ашиг /мян.төг/
1	Би Ди Сек	522	UB	11 000 000	11,78	ҮЦГТТХТ	9 754 285,70	288 127,80
2	Тахько	44	UB	1 189 983	65	ҮЦГТТХТ	1 950 969,10	281 547,30
3	Говь	354	UB	7 801 125	130	ХК, ҮЦГТТХТ	81 227 070,50	7 102 877,20
4	Гермес центр	528	UB	78 543 001	5,82	ХК, ҮЦГТТХТ	8 488 868,50	457 129,50
5	Ачит алхабы	200	BE	74 127	10	ҮЦГТТХТ	54 906,90	1 123,80
6	Махимпекс	208	UB	3 800 721	100	ХК	19 761 169,90	1 907 070,90
7	Эрдэнэт суврага	377	BU	156 054	5	ҮЦГТТХТ	2 357 765,00	(218 993,40)
8	Талх чихэр	22	UB	1 023 703	110	ХК	28 748 068,00	2 229 972,80
9	Баянгол ЗБ	13	UB	423 065	355	ХК, ҮЦГТТХТ	36 021 336,90	3 448 275,80
10	Техникимпорт	441	UB	1 446 755	200	ХК	13 572 848,70	1 019 901,60
11	Газар сүлжмэл	34	UB	65 362	7233,39	ХК	1 336 521,10	472 789,00
12	Хөвсгөл геологи	108	HE	143 959	85	ХК, ҮЦГТТХТ	1 085 829,30	30 739,50
13	АПУ	90	UB	74 287 700	90	ҮЦГТТХТ	267 065 139,10	4 024 307,60
14	Адуунчулуун	461	DO	3 151 304	75	ҮЦГТТХТ	9 549 672,40	533 863,00
15	Хүрд	8	UB	135 266	253	ҮЦГТТХТ	10 819 090,10	342 604,60
16	Атар өргөө	17	UB	174 136	300	ҮЦГТТХТ	7 634 977,70	74 452,00
17	Ган хэрлэн	353	DO	99 899	300	ҮЦГТТХТ	2 279 997,10	54 395,80
18	Ээрмэл	191	UB	3 479 320	63,1	ҮЦГТТХТ	60 799 076,10	660 841,60

19	Улаанбаатар ЗБ	3	UB	335 297	330	ҮЦГТТХТ	13 955 306,80	2 775 693,50
20	Могойн гол	444	HE	829 622	5	ҮЦГТТХТ	2 824 677,50	33 646,60
21	Гугал	88	UB	1 618 684	349	ХК	5 267 592,40	550 305,70
22	Тээвэр Дархан	217	DA	163 349	400	ҮЦГТТХТ	1 606 714,20	159 002,10
23	Монгол алт	68	DA	265 852	150	ҮЦГТТХТ	1 305 649,30	(125 738,40)
24	Барилга	476	UB	40 662	5500	ХК	14 927 943,40	360 744,00
25	Баянтээг	445	EV	252 608	100	ҮЦГТТХТ	2 228 022,50	394 077,10
26	Таван толгой	458	EM	52 665 200	766	ҮЦГТТХТ, ХК	112 335 058,10	62 096 483,90
27	Гермес центр	528	UB	78 543 001	6,11	ҮЦГТТХТ, ХК	8 584 365,50	480 103,30

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ДЭД БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн статистик үзүүлэлтүүд:

2014 оны байдлаар Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй арилжаа эрхлэх 1, төлбөр, тооцоо, хадгаламжийн 1, брокер, дилерийн 66 компани, Засгийн газрын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар хөрөнгө оруулалтын ажил үйлчилгээ эрхлэх 10, мөнгөн хөрөнгийн төлбөр гүйцэтгэх 5 арилжааны банк, хөрөнгө оруулалтын менежментийн 3 компани, давхардсан тоогоор андеррайтерийн тусгай зөвшөөрөлтэй 24, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх 15, кастодиан үйлчилгээ үзүүлэх арилжааны 2 банк байна.

График - 7



Тайлант хугацаанд Хорооноос дараах тусгай зөвшөөрөл болон зөвшөөрлийг тус тус олгоод байна. Үүнд:

Хүснэгт-5

д/д	Тусгай зөвшөөрлийн төрлөөр	2014 оны байдлаар
1	Тусгай зөвшөөрөл шинээр авсан	

	<i>Брокер, дилерийн</i>	1
	<i>Хөрөнгө оруулалтын менежмент</i>	3
	<i>Хөрөнгө оруулалтын зөвлөх</i>	1
	<i>Кастодианы үйлчилгээ эрхлэх</i>	2
2	Тусгай зөвшөөрөл нэмж авсан	1
3	Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн	18
4	Тусгай зөвшөөрлийг сэргээсэн	2
5	Тусгай зөвшөөрлийг сунгасан	-
6	Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон	24
7	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулсан	9
8	Гүйцэтгэх захирлаа шинээр томилсон	7
9	Оноосон нэрээ өөрчилсөн	1
10	Орон нутагт салбар нээх зөвшөөрөл авсан	-
11	Номиналь данс эзэмших зөвшөөрөл авсан	1
12	Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах зөвшөөрөл авсан	4

Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдүүдийн өнөөгийн байдал:

1991 онд “Монголын хөрөнгийн бирж” ХК байгуулагдаж, өмч хувьчлалын эрхийн бичгийн бүртгэлийн болон брокерийн зуучлалын үйлчилгээг орон нутагт хүргэх чиглэлээр 21 брокер, дилерийн пүүс байгуулагдсан.

Брокерийн пүүсүүд нь тухайн орон нутгийн иргэдийн цэнхэр, ягаан тасалбарыг баталгаажуулан, хувьчлагдсан компанийн үнэт цаасанд анхдагч зах зээлийн арилжаагаар хөрвүүлэх бүртгэлийг хөтлөх, данс нээх ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байсан. Улмаар 1995 онд хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх, иргэдэд брокерийн үйлчилгээг үзүүлэх, ногдол ашиг, ногдол хувийн мөнгөн хөрөнгийг тараах ажиллагааг гүйцэтгэж байсан.

1995- 2002 оны хооронд Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэнтэй холбоотойгоор мэргэжлийн зуучлагч байгууллагуудын боловсон хүчний мэдлэг чадвар дутмаг, санхүүгийн чадавх сул, ёс зүйгүй байдлаас үүдэн хувьцаат компанийн удирдлага, дотоод мэдээлэл эзэмшигч нартай хувилдан иргэдийн хувьцааг тэдний зөвшөөрөлгүйгээр худалдах, бусдад шилжүүлэх, ногдол ашиг, ногдол хувийн мөнгийг хувьдаа завших хууль бус үйлдлийг ихээр гаргах болсон. Дээрх хууль бус үйлдэлд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо бүрдээгүй, төрийн зохицуулах байгууллагын зүгээс тавих хяналт сул байдал нь ихээхэн нөлөө үзүүлсэн.

2002-2006 оны хооронд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор мэргэжлийн оролцогч байгууллагуудын дүрмийн сангийн хэмжээ нэмэгдэж, төрөөс тавих хяналт, зохицуулалтын тогтолцоо бий болсон бөгөөд брокер, дилерийн компани нэгдэж нийлэх ажиллагаа идэвхжиж, санхүүгийн хувьд чадавхи сул компаниуд татан буугдсан. Мөн төрийн зохицуулах байгууллагаас арилжааны бус хэлцлийг нэмэгдүүлэх чиглэлээр алдаатай шийдвэр гаргаж, брокерийн зуучлагч компанид хэрэгжүүлэх эрх олгосон нь эргээд компанийн хувьцааны хяналтын багцыг цөөн тооны этгээдүүдийн гарт төвлөрөх нөхцлийг бүрдүүлсэн.

2007-2008 оны хооронд эдийн засгийн нөхцөл, байдал сайжирч андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооноос олгож эхэлсэнтэй холбоотойгоор

зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болох, хөрөнгө оруулагчдыг үнэт цаасны зах зээлд хандах хандлага нэмэгдэж, анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаанд брокерийн зуучлалын үйлчилгээ идэвхжиж, мэргэжлийн зуучлагч байгууллагуудын тоо нэмэгдсэн.

2009-2010 онд Дэлхийн эдийн засагт бий болсон санхүүгийн хямралын нөлөөлөл нь манай орны үнэт цаасны зах зээлд сөргөөр нөлөөлж, шинээр үнэт цаасны зах зээлд гаргасан арилжааны банкуудын хэвийн үйл ажиллагаа алдагдаж, Монголбанкнаас эрх хүлээн авагчийг томилох шийдвэр гарган, татан буулгах ажиллагааг эхлүүлсэн нь эргээд иргэдийн зах зээлд итгэх итгэлийг бууруулах, мэргэжлийн зуучлагч байгууллагуудын зуучлалын үйлчилгээ буурах нөхцөл болсон.

2011-2012 оны хооронд уул уурхайн салбарын огцом өсөлтөөс шалтгаалан хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын хувьцааны үнэ ханш огцом өсч, төрөөс иргэдэд үнэ төлбөргүйгээр “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 1072 ширхэг хувьцааг үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэх шийдвэр гаргасантай холбоотойгоор брокерийн компаниар дамжуулан үнэт цаасны данс нээх ажиллагаа идэвхжиж, брокерийн компанийн тоо эрс нэмэгдэх нөхцлийг бүрдүүлсэн.

2013-2014 онд эдийн засгийн өсөлт удааширч, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын зах зээлд хөрөнгө оруулах сонирхол буурч, мөн “Монголын хөрөнгийн бирж” ХК-д нэвтрүүлсэн арилжаа, тооцоо, хадгаламжийн МИТ системийн зохицуулалтаас үүдэн брокерийн компанид нэмэлт санхүүгийн ачааллыг бий болгосон нь эргээд брокерийн компанийн тоог буурах нөхцлийг бүрдүүлсэн.

Мэргэжлийн голлогч зуучлагч байгууллагууд болох брокер, дилер, андеррайтерийн компаниудын үйл ажиллагаа эдийн засгийн өсөлтөөс ихээхэн хамааралтай, санхүүгийн болон хүний нөөцийн чадавх сул байгаа нь зуучлалын үйлчилгээг хэвийн тасралтгүй үзүүлэхэд ихээхэн саад болж байна.

Тиймээс үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн зуучлагч байгууллагуудын санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэн, цөөн тооны чадварлаг зуучлагч байгууллагуудаар зуучлалын үйлчилгээг хүргэх тал дээр анхаарал хандуулах, банк, түүний охин хараат компаниар холбогдох зуучлалын үйлчилгээг хүргэх чиглэлд анхаарал хандуулах шаардлагатай байна.

Үнэт цаасны төлбөр, тооцоо, төвлөрсөн хадгаламжийн статистик үзүүлэлтүүд:

2014 оны байдлаар төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн дансаар 489 харилцагчийн 2171 удаагийн нийт 1.6 их наяд төгрөгийн орлого, 2359 харилцагчийн 3476 удаагийн нийт 1.6 их наяд төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн байна. Үүнд Монголбанкаар дамжин явагдаж байгаа бондын гүйлгээ орсон болно.

Тайлант хугацаанд “ҮЦТТХТ” ХХК-иар дамжуулан үнэт цаасны төлбөр гүйцэтгэх 4 банк хооронд нийт 9.4 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдснээс “Голомт банк” ХХК-иар 3.9 тэрбум, “Худалдаа хөгжлийн банк” ХХК-иар 1.6 тэрбум, “Хас банк” ХХК-иар 1.6 тэрбум, “ХААН банк” ХХК-иар 2.1 тэрбум төгрөгийн гүйлгээ тус тус хийгдсэн байна.

**"ҮЦТТХТ" ХХК-иар дамжин
хийгдсэн гүйлгээ хувиар**




2014 оны жилийн эцсийн байдлаар барьцаа хөрөнгийн санд 61 брокер, дилерийн компанийн 691.8 сая төгрөг, төлбөрийн баталгааны санд 68 брокер, дилерийн компанийн 296.3 сая төгрөгийг төлбөрийн баталгааны санд тус тус байршуулаад байна.

Үнэт цаасны хоёрдогч зах зээл эхэлснээс хойш төвлөрсөн хадгаламжид өссөн дүнгээр шинээр 785,863 холболтын 133,412 данс нээгдсэнээс, дотоодын иргэний 781,489 гадаадын иргэний 1,768 дотоодын аж ахуйн нэгжийн 2,429, гадаадын аж ахуйн нэгжийн 177 данс бүртгэгдээд байна.

График - 9

Данс эзэмшигчийн мэдээлэл



2013 оны байдлаар төвлөрсөн хадгаламжид шинээр нийт 10,540 данс нээгдсэнээс, дотоодын иргэн 10,448, гадаадын иргэн 43, дотоодын аж ахуй нэгж 35, гадаадын аж ахуйн нэгжүүд 14 данс нээлгэсэн байна. 2012 оноос үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид нээгдсэн дансны тоо эрс өссөн нь төрөөс “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 1072 ширхэг хувьцааг үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэх шийдвэр голлон нөлөөлсөн.

2012 оноос дотоодын иргэдийн данс нээх ажиллагаа өссөн боловч гадаадын иргэн, аж ахуйн нэгжийн данс нээх ажиллагаа буурсан үзүүлэлт ажиглагдаж байна.

Үнэт цаасны зах зээлд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын арилжааны дүнд эзлэх хувь:

2014 оны байдлаар арилжааны үнийн дүнд гадаадын аж ахуйн нэгжийн эзлэх хувь 2013 оны мөн үетэй харьцуулахад 10 хувиас 4 хувь буурсан бол дотоодын аж ахуйн нэгжийн арилжааны үнийн дүнд эзлэх хувь 82 хувиас 58 хувь болж буурсан үзүүлэлттэй байна. Харин гадаад иргэний арилжааны үнийн дүнд эзлэх хувь 2 хувиас 5 хувь болж 2.5 дахин өссөн бол дотоодын иргэдийн хувь 6 хувиас 33 хувь болж 5.5 дахин өссөн дүнтэй байна. Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь хэмжээг хүснэгтээр үзүүлбэл дараах байдалтай байна.

Хүснэгт-6

	Нийт хувьцааны гүйлгээний дүн /тэрбум төгрөгөөр/	Нийт арилжаанд эзлэх%	
		Гадаад	Дотоод
2006	18	27.2	72.8
2007	102.4	37.5	62.5
2008	62.3	24.1	75.9
2009	23.2	31.9	68.1
2010	92.8	62.2	37.8
2011	109.1	23.6	76.4
2012	144.7	92	8
2013	97.6	12	88
2014	60.4	9	91

График – 10



2014 онд арилжааны үнийн дүнд гадаадын иргэд, аж ахуйн нэгжийн эзлэх хувь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад буурсан нь дараах хүчин зүйлс нөлөөлсөн

гэж үзэхээр байна. Үүнд:

- Улс орны эдийн засгийн нөхцөл байдал тааруу, гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин тодорхойгүйгээс гадаадын болон дотоодын биржид бүртгэлтэй уул уурхайн компаниудын хувьцааны үнэ, ханш унасан;

- Шинэ системтэй уялдан арилжааны банкинд үнэт цаасны мөнгөн төлбөр тооцооны данс нээх, түүний гүйцэтгэлийн ажилбаруудыг гүйцэтгэхэд аль аль талдаа чирэгдэл үүссэн;
- Гадаадын хөрөнгө оруулагчдын хэрэгцээ, шаардлагад нийцсэн, тэдгээрийн өмчлөх эрхийг нь баталгаажуулах, эрхээ хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл болох кастодиан банкны үйлчилгээ зах зээлд хараахан нэвтрээгүй, хөрөнгө оруулалтын сангууд үүсэн бий болоогүй;
- Зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлт дутмаг, хөрвөх чадварын түвшин доогуур байгаа зэрэг нь нөлөө үзүүлж байна.

2014 онд үнэт цаасны зах зээлд гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүлэх, тэдний өмчлөх эрхийг баталгаажуулах чиглэлээр кастодиан банкны үйлчилгээг нэвтрүүлэх, брокерийн компани номинал дансаар дамжуулан мөнгөн хөрөнгийн гүйлгээг хийх зохицуулалтын орчинг бүрдүүлээд байгаа бөгөөд мөн онд 2 банк кастодианы үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг брокер, дилерийн 1 компани номинал дансаар үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийг тус тус аваад байна.


Хорооны зүгээс 2015 онд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу өмчлөх эрхийн тухайлсан болон төвлөрсөн бүртгэлийг зааглах тухайлсан бүртгэлийн үйл ажиллагааг кастодиан банкаар дамжуулан гүйцэтгүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Үнэт цаасны зах зээлийн дэд өнөөгийн байдал, цаашдын хандлага:

Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн үр ашигтай, найдвартай, хурдан шуурхай байдал нь хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлд, хөгжилд голлогч нөлөөллийг үзүүлдэг. Өөрөөр хэлбэл хөрөнгийн бирж дээр хийгдсэн арилжааны дараа худалдагч худалдан авагч нарт үнэт цаас, мөнгөн хөрөнгийн өмчлөх эрх хурдан шуурхай, үр ашигтай хэлбэрээр шилжүүлэх асуудал зах зээлийн дэд бүтцийн уялдаа, холбоо, хөгжлөөс ихээхэн хамаардаг.

Олон улс орнуудад хэрэглэгдэж буй зах зээлийн дэд бүтцийн нийтлэг бүтцийг хүснэгтээр үзүүлбэл дараах байдалтай байна.

Хүснэгт-7



↓

Үнэт цаас хадгалах ажиллагаа /CSD/

1995 оноос үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа “Монголын хөрөнгийн бирж” ХК-д хийгдсэж эхэлсэн бөгөөд 2012 оны 7 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл “Бодь” ХХК-ийн охин компани “ЕСМ” ХХК-ийн боловсруулсан арилжаа, төлбөр, тооцоо, хадгаламжийн програм хангамжийг ашиглаж байсан. Энэхүү програм хангамж нь **брокерийн үйл ажиллагаанд илүү тохиромжтой харилцагч** үнэт цаасны төлбөрөө 100% байршуулсан тохиолдолд захиалгыг арилжаанд оруулан өмчлөх эрхийг баталгаажуулдаг програм юм. Арилжааны төлбөр, тооцооны горим нь T+0 хугацаанд гүйцэтгэхээр зохицуулагдаж, харилцагч үнэт цаас худалдан авах төлбөрөө “ҮЦТТТХТ” ХХК-ийн тусгайлсан дансанд байршуулан арилжаанд оролцож, “ҮЦТТТХТ” ХХК нь үнэт цаас худалдсан харилцагчийн мөнгөн төлбөрийг мөнгө хүсэх өргөдлийг үндэслэн арилжааны банкны дансанд шилжүүлдэг байв.

Дээрх хугацаанд арилжааны дараах буюу төлбөр, тооцооны ажиллагааг “ҮЦТТТХТ” ХХК-ийн E-Clearing house програмаар гүйцэтгэдэг байсан ба дээрх програм нь Монголбанкны төлбөр тооцооны RTGS системтэй холбогдсноороо давуу талыг бий болгож байсан.

2012 оны 7 дугаар сарын 02-ны өдрөөс “Монголын хөрөнгийн бирж” ХК, “ҮЦТТТХТ” ХХК-д арилжаа, тооцоо, хадгаламжийн MIT системийг албан ёсоор ашиглаж эхэлсэн.

Энэхүү систем нь брокерийн үйл ажиллагааг дэмжих гэхээсээ илүүтэйгээр дилерийн үйл ажиллагаанд тулгуурласан хөрөнгө оруулалтын сангийн эзэмшиж буй багцын гүйлгээг хийх, их хэмжээний захиалгыг нэгэн зэрэг цаг хугацааны хоцролтгүйгээр биелүүлэх, маржин арилжаа буюу зээлээр үнэт цаас худалдах ажиллагааг T+3 хугацаанд гүйцэтгэх, харилцагчийн мөнгөн хөрөнгийн төлбөр, тооцоог кастодиан банкиар дамжуулан гүйцэтгүүлэх зорилгоор зохиогдсон програм юм. Өөрөөр хэлбэл томоохон хөрөнгө оруулагч, хөрөнгө оруулалтын сан, market making ажиллагаанд тулгуурласан шинжтэй зах зээлд томоохон тоглогчид оролцож, үнэт цаасны үнэ ханшийг тогтоох, их хэмжээний дүнтэй арилжааг дэмжих зарчмыг өөртөө агуулсан систем билээ.

Уг систем нь брокерийн үйл ажиллагааг дэмжсэн шинжийг агуулаагүй болохоор харилцагчийн үнэт цаас худалдан авах зорилгоор төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг хянан баталгаажуулдаггүй, анхдагч зах зээлийн арилжааг хөрөнгө оруулалтын банк буюу андеррайтерийн компани гүйцэтгэх, мөнгөн төлбөр тооцоог кастодиан банк гүйцэтгэхээр зохиогдсон тул зах зээлийн дэд бүтцийн хүрээнд зарим нэг сул талуудыг бий болгож байна.

MIT системийг ашиглаж эхэлснээс хойших хугацаанд дэд бүтцийн хүрээнд дараах хүндрэлтэй асуудлуудыг бий болгож байна. Үүнд:

- Анхдагч зах зээлийн арилжааны програм хангамж байхгүй тул “МХБ” ХК болон “ҮЦТТТХТ” ХХК нь анхдагч зах зээлийн арилжааны хуучин програм хангамжийг ашиглан арилжаа хийж гүйцэтгэн, гар ажиллагаагаар шимтгэлийн тооцооллыг хийх, MIT CSD системд шинэ өмчлөгчийн мэдээллийг шивж, оруулах ажиллагааг гүйцэтгэж байна.

- Компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах ажиллагаа /takeover bid/ -г “ҮЦТТТХТ” ХХК-ийн CSD програмаар дамжуулан захиалгыг бүртгэн, “МХБ” ХК хэлцлийг биелүүлж байгаа нь харилцагчийн захиалга биелэгдэхгүй байх, тендер саналын арилжаа амжилтгүй болох эрсдлийг бий болгоод байна.
- Үнэт цаасны төлбөр тооцоог гүйцэтгэх бие даасан CCP програм хангамж байхгүй тул мөнгөн хөрөнгийн төлбөр тооцоо, банк хоорондын гүйлгээг E-Clearing house програмаар гүйцэтгэн мэдээллийг гараар MIT CSD системд шивж оруулж байна.
- Кастодиан банк, төвлөрсөн хадгаламжийн байгууллага хооронд харилцагчийн дансны мэдээллийг тулгах, бүртгэх, үлдэгдэл тулгах програм хангамжийг бүрэн туршиж дуусаагүй, нийт 7 төрлийн асуудал гарсныг MIT тайлбар тавиад байна.

Цаашид Хорооны зүгээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага бий болоод байна. Үүнд:

- Бие даасан төлбөр, тооцооны байгууллагыг бий болгох;
- Анхдагч зах зээлийн арилжааг андеррайтерийн компани захиалгын бүртгэлийн аргаар бүртгэн явуулах зохицуулалтыг бий болгох;
- Үнэт цаасны мөнгөн төлбөр гүйцэтгэгч клиринг банкинд гадаадын иргэн, аж ахуйн нэгжийн данс нээх ажиллагааг хөнгөвчлөх хурдан шуурхай нээх боломжийг бүрдүүлэх;
- Кастодиан банкны үйлчилгээг 2015 онд багтаан нэвтрүүлэх чиглэлээр номинал дансыг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид данс нээх, мэдээлэл солилцох туршилтын хүрээнд үүссэн 7 асуудлыг хурдан шуурхай шийдвэрлэх;
- “ҮЦТТТХТ” ХХК-д хадгалагдаж байгаа харилцагчийн ногдол ашиг, ногдол хувийн мөнгөн хөрөнгийг харилцагчийн арилжааны банкинд шилжүүлэх.

ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ГАЗАР
ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ХЭЛТЭС